МЭДЭЭ · 2023 оны 6-р сарын 30

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГ, МАТЕРИАЛУУДЫГ ХЯНАЖ ДУУСЛАА



Улсын ерөнхий прокурорын газраас гадаадын хөрөнгө оруулалттай, аж ахуйн нэгж хохирсон, холбогдсон гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явц, шийдвэрлэлтийн байдлыг улсын хэмжээнд нэгтгэн судалж, хянах ажлын хэсгийг байгуулсан талаар өмнө нь мэдээлсэн. /энд дарж үзнэ үү/

Сүүлийн 6 жилийн хугацаанд гадаадын хөрөнгө оруулагч нартай холбоотой 342 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс гадаадын хөрөнгө оруулагч хохирсон 239, гадаадын хөрөнгө оруулагч холбогдсон 103 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн дийлэнх нь уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой байх бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч хохирсон хэргийн 65,9 хувийг залилах гэмт хэрэг, бусад нь хөрөнгө завших, хулгайлах, мөнгө угаах, хүрээлэн байгаа орчны эсрэг, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх болон авлигын гэмт хэрэг эзэлж байна.

Хохирсон гэх гадаадын хөрөнгө оруулагчийн 44.5 хувь нь БНХАУ, 8.6 хувь нь БНСУ-ын иргэд, 28.5 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байх ба гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос 12,0 тэрбум төгрөгийн хохирлыг хэргийг мөрдөн

шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хохирсон 31, холбогдсон 8 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, 8,4 тэрбум төгрөгийн хохирлыг шүүхийн шийдвэрээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлүүлсэн.

Ажлын хэсэг хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон 174, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа 78, нийт 252 хэргийг хянаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэргүүдийн 83.3 хувьд нь тодорхой ажиллагаа хийлгүүлэхээр прокурорын даалгавар бичиж, хэргийг шуурхай шалгаж, шийдвэрлэх үүргийг мөрдөх байгууллага болон хяналт тавьж буй нэгж прокурорын газарт өгсөн байна.

Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны явцад нотолбол зохих асуудлыг бүрэн шалгаж тогтоогоогүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон 4 хэргийг сэргээж, нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр харьяа мөрдөх байгууллагад хүргүүлжээ.

Тухайлбал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн “Монгол Улсын иргэн Э нь 2011-2023 онд Сингапур улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Ай Ти Жи Эм” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байхдаа тус компанийн эзэмшилд авах газрын төлбөрт өгнө гэж Австрали Улсын нэр бүхий иргэнээс 8,9 сая ам.доллар буюу 12,0 тэрбум төгрөгийг шилжүүлэн авч завшсан” гэх,

Монгол Улсын иргэн Б, И нар нь бүлэглэж 2019 онд баримт бичиг хуурамчаар үйлдэн ашиглаж, Хаан банкны тооцооны төвөөс Монгол Улсад бизнес хийх зорилгоор ирсэн БНХАУ-ын иргэний данснаас 1,3 тэрбум төгрөгийг бусдын данс руу шилжүүлж, бэлнээр гаргуулан авч залилсан” гэх хэргийг хаасан шийдвэрийг тус тус хүчингүй болгож, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгүүлэхээр прокурорын даалгавар бичиж хүргүүлсэн байна.

Цаашид мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж, хүний эрхийг зөрчихгүй байх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хэргийг богино хугацаанд хянан шийдвэрлэхэд анхаарч ажиллахыг мөрдөгч, прокуроруудад үүрэг болголоо.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1550